



**САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар
2025 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	3
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	4
ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	7
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	15

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоож арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад энэхүү үнэлгээний ажлын зорилго нь оршино.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалтууд нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийснээс гадна хуулийн төслийн зохицуулалт практикт хэрэгжих боломжийг туршсан байдалд дүн шинжилгээ хийсэн болно. Мөн хуулийн төслийн зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдөх боломжтой, ойлгомжтой байдлаар тусгагдсан эсэх тухай холбогдох байгууллагаас санал авч, хуулийн төслийн зохицуулалтууд нь ойлгомжтой, харилцан уялдаатай байгаа эсэхийг дээр дурдсан аргачлалын дагуу асуултад хариулах байдлаар дүгнэсэн бөгөөд, гарсан үр дүнд үндэслэн анхаарах асуудлын талаар хууль санаачлагчид зөвлөмж өгсөн.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгох болсон үндэслэл нь Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн үндсэн зорилго

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

болон зохицуулах харилцааны онцлогтой холбоотой. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын өнөөгийн санхүүгийн нөхцөл байдлаас хамаарч санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалж, түүнд санхүүгийн мэдлэг боловсролыг зөв хүртээмжтэй олгосноор цаашдын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хамгаалахад хуулийн үндсэн зорилго чиглэгдэж буйг анхаарч, нэгдүгээрт Монгол Улсад санхүүгийн хэрэглэгч, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хангах, хамгаалах талаар шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлсэн байдал, хоёрдугаарт санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага болон зохицуулагч байгууллагаас хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбоотой зохицуулалтад дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэсэн үндэслэлээр сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ зэргээр энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг судлах, урьдчилан үнэлэх зорилгоор энэхүү шалгуурыг сонгож авлаа.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн зохицуулалтад шууд хамаарах этгээд хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгахын тулд сонгосон болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөний үнэлгээг хийхээр сонгов.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төслийн голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судална.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр хэлтэс, нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон. Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

3.1.Зорилгод хүрэх байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод уг хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлал, тандан судалгаатай танилцаж, хуулийн төслийн зорилго нь хуулийн төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг шалгах, хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг хуулийн төслийн зорилготой харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл, хуулийн төсөл нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгыг дэвшүүлжээ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд:

1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоож, санхүүгийн хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, ойлголтыг үнэн бодитоор үнэ төлбөргүй авах эрхийг хуульчлах,
2. Санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн мэдлэгийн дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, салбарын итгэлцлийг нэмэгдүүлэх,
3. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, ингэснээр санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, өрсөлдөөнт орчныг бэхжүүлэх,
4. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хяналт тавих зохицуулалтыг тодорхой болгохтой холбоотой зохицуулалт хийх.

Дээрх зорилго, зорилтыг харгалзан хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс дараах зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо.

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоож,	10 дугаар зүйл.Санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага

	санхүүгийн хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, ойлголтыг үнэн бодитоор үнэ төлбөргүй авах эрхийг хуульчлах	6.1.2.санхүүгийн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээний үнэ, нөхцөл, эрсдэлийн талаар ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллийг үнэ төлбөргүйгээр авах эрхтэй.
2	Санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн мэдлэгийн дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, салбарын итгэлцлийг нэмэгдүүлэх,	14 дүгээр зүйл.Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа
3	Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, ингэснээр санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, өрсөлдөөнт орчныг бэхжүүлэх,	6 дугаар зүйл.Санхүүгийн хэрэглэгчийн эрх. 8 дугаар зүйл.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг. 9 дүгээр зүйл.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хориглох зүйл.
4	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хяналт тавих зохицуулалтыг тодорхой болгохтой холбоотой зохицуулалт хийх.	15 дугаар зүйл.Зохицуулагч байгууллагын бүрэн эрх

3.2. “Практикт хэрэгжих боломж”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломж байна уу гэдгийг үнэлэх үүднээс хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалтыг сонгож авлаа.

15.1.Зохицуулагч байгууллага нь хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.8.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байна.

3.3.Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх, байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлахаар хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн дараах зүйл, хэсэг, заалтыг сонгож авав.

12.3.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гомдлыг амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр үнэ төлбөргүй хүлээн авна.

12.5. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авснаас хойш шууд шийдвэрлэх боломжтой бол ажлын гурав хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.4. Ойлгомжтой байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 17 зүйлтэй./

3.5. Харилцан уялдаа

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 17 зүйлтэй./

ДӨРӨВ: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон бөгөөд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон аргачлалд тодорхойлогдсон дараах шалгах хэрэгслүүд байна.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	10 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага 5.1.2. санхүүгийн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээний үнэ, нөхцөл, эрсдэлийн талаар ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллийг үнэ төлбөргүйгээр авах эрхтэй. 14 дүгээр зүйл. Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа 6 дугаар зүйл. Санхүүгийн хэрэглэгчийн эрх. 8 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг. 9 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хориглох зүйл. 14 дүгээр зүйл. Зохицуулагч байгууллагын бүрэн эрх	Зорилгод дүн шинжилгээ хийх

2	Практикт хэрэгжих боломж	15.1.Зохицуулагч байгууллага нь хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ. 15.8.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байна.	<u>Практикт турших</u>
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	<u>Ойлгомжтой байдлыг судлах</u>
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	12.3.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гомдлыг амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр үнэ төлбөргүй хүлээн авна. 12.5.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авснаас хойш шууд шийдвэрлэх боломжтой бол ажлын гурав хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар өмнө хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх
5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийг үйл ажиллагааны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль зэрэг хуулиудад туссан санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой зохицуулалт болон энэ хуулийн төслийн хүрээнд дэвшүүлэн тавьсан зорилгыг харьцуулан дүгнэхэд хуулийн төсөлд илүүтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүтээгдэхүүн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоох, санхүүгийн хэрэглэгчдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл өгөх, санхүүгийн мэдлэг олгох, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд зохицуулагч байгууллагын бүрэн эрхийг тодорхойлоход анхаарсан болох нь харагдаж байна.

Хуулийн төслийн зорилгыг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэхэд оршихоор тодорхойлсон бөгөөд хуулийн төслийг дагалдан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, уг хуулийн төсөлд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар зохицуулсан харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заажээ. Энэ нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн зохицуулах хаилцаа нь энэ хуулиар зохицуулах харилцаатай давхцахгүй байх давуу талтай болсон гэж үзэж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол улсад санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой болон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалт байхгүй, мөн зохицуулагч байгууллагаас санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчид санал болгож, хүргэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд чиглэсэн санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа тухай дурджээ.

Түүнчлэн санхүүгийн зах зээлд хэрэглэгчийн эрхийг хамгаалах хэрэгцээ шаардлага, үндэслэл нь эрх мэдэл, мэдээлэл, нөөц боломжийн тэнцвэргүй байдлаас урган гарч байгаа бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч талуудын хувьд санал болгож буй бүтээгдэхүүнийхээ талаар бүрэн мэдээлэлтэй байдаг бол иргэд, харилцагчдын хувьд худалдан авч буй бүтээгдэхүүнийхээ талаар бүрэн мэдээллийг олж авах нь өртөг зардалтай, эсхүл бэрхшээлтэй байдаг байна.

Хуулийн төсөлд санхүүгийн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээний үнэ, нөхцөл, эрсдэлийн талаар ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллийг үнэ төлбөргүйгээр авах эрхтэй, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа тухайн гэрээний агуулга, нөхцөл, хүү, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр, тэдгээрийг тооцсон аргачлалыг танилцуулж, тайлбарлах үүрэгтэй, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтан, ажилтныг мэргэшүүлэх, ёс зүйн болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн сургалтын агуулга, төлөвлөгөөг зохицуулагч байгууллага болон салбар бүрийн мэргэжлийн холбоод баталж, хэрэгжүүлэх, зохицуулагч байгууллага нь хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх, болон холбодох бүрэн эрхийг нарийвчлан тусгасан байна.

Иймд хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд нь түүнийг боловсруулах болсон зорилго, үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцтэй үзэж байна.

4.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэхээр хуулийн төслөөс сонгож авсан дараах зохицуулалтын талаар туршсан байдалд дүн шинжилгээ хийх, санал авч дүгнэлт гаргах замаар үр нөлөөг судаллаа.

15.1.Зохицуулагч байгууллага нь хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.8.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байна.

Одоогийн байдлаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээдийн санхүүгийн чадварт үндэслэн санхүүгийн системд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохистой хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна. Тус хуулийн төсөл батлагдсанаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдэх бөгөөд зохицуулагч байгууллагаас хуулийн төсөл, түүний зохицуулах харилцааг таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлуудыг зохион байгуулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

2018 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монголбанк, СЗХ болон АХБ хооронд “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төслийн нэг зорилго нь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын чадамжийг сайжруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх зэрэг юм. Төслийн хүрээнд зохицуулагч байгууллагын хянан шалгагч нарыг санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтын талаар сургалт, семинарт хармруулж байна.

Иймд хуулийн төслийн дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд учрах саад бэрхшээл байхгүй буюу практикт шууд хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

4.3 “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг хэрэглэх байгууллага хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой эсэх тухай хуулийн төслийн зохицуулалтын нөлөөлөхүйц байдал, хэрэгжих боломжийн судалгааг хуулийн дараах зүйл, хэсэг, заалтын хүрээнд судалж, дүн шинжилгээ хийлээ.

13.3.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гомдлыг амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр үнэ төлбөргүй хүлээн авна.

12.5.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авснаас хойш шууд шийдвэрлэх боломжтой бол ажлын гурав хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Манай улсын хувьд санхүүгийн үйл ажиллагаа нь тогтсон үйл ажиллагаа хэдий ч практикт дараах хүндрэл бэрхшээлүүд тулгардаг байна. Жишээ нь: Монгол улсын насанд хүрсэн хүн амын 93 хувь нь албан ёсны санхүүгийн байгууллагад данс эзэмшдэг гэж 2017 оны Глобал Финдекс² мэдээллийн санд бүртгэгдсэн байна. Мөн хуулийн төслийн тандан судалгаанд дурдсанаар сүүлийн жилд дотоод аудит болон хяналт шалгалтаар иргэн аж ахуйн нэгжтэй холбоотой 47 мянган зөрчил илэрсэний 99.2 хувь нь иргэдийн, үлдсэн хэсэг нь аж ахуйн нэгжтэй холбоотой асуудал байна. Гэтэл мөн хугацаанд банкинд иргэдээс 6.5 мянган өргөдөл буюу нийт бүртгэгдсэн зөрчлийн 14 хувь нь банкинд гомдол гаргажээ. Үүнээс харахад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой асуудлаар хэрэглэгчдийн зүгээс өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэхэд хүндрэлтэй байдаг эсвэл хэрэглэгчид зөрчил гомдлын талаар мэдээлэлгүй, хэрхэн шийдвэрлүүлэх талаар ойлголтгүй байдагтай холбоотой байна.

Иймд хуулийн төсөлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр үнэ төлбөргүй хүлээн авах талаар болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх талаарх зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

4.4 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл буюу хуулийн төслийг боловсруулахад оролцсон Ажлын хэсгийн гишүүдээс санал авахад хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй тухай дараах саналаа ирүүлсэн.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг

² World bank, The Global Findex database,(2017), p125

	<p>зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлд төрд эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах үүргийг хүлээлгэсэн бөгөөд энэ талаар хуульчлан баталгаажуулсантай хуулийн төсөл нийцэж байна.</p> <p>УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн 2-т “санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, санхүүгийн маргааныг олон улсын шилдэг туршлагад үндэслэн шийдвэрлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх”-ээр, 2021 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн хавсралтын 3.3-т “санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжих”-ээр тус тус тусгагдсан.</p> <p>Хуулийн төслийн зохицуулалтууд нь Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөх зохицуулалт агуулаагүй байна.</p>
<p>29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна.</p>
<p>29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна.</p>
<p>29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна.</p>

29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт; 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.	Уг шаардлагыг хангасан байна. Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх; 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.	Уг шаардлагыг хангасан байна. Хуулийн төслийг дагалдан гарах Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Төв банк (Монголбанк)-ны тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний	Хуулийн төслийн зорилго нь тодорхой төрлийн нийгмийн харилцааг зохицуулах, иргэний ямар нэгэн үндсэн эрхийг хангахтай холбоотой байдаг ба энэ хуулийн төслийн зорилго санхүүгийн

<p>үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.</p>	<p>хэрэглэгчийн эрхийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгыг тавьсан олон улсын зарчим, зохицуулалттай бүрэн нийцэж байна. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсон.</p>
<p>29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн.</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна. Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.</p>
<p>29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн.</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна. Хуулийн төслийг дагалдан гарах Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Төв банк (Монголбанк)-ны тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан байна.</p>
<p>29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн.</p>	
<p>29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана. 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн.</p>	

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан байна.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан байна.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан байна.

4.5 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуулийн төсөл нь “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” гэсэн нэртэйгээр боловсруулагджээ. Хуулийн төслийн нэр нь хуулийн төслийн зорилготой уялдаж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Нийцтэй байна.
Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Давхардаагүй байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Орхигдуулаагүй байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Давхардуулаагүй байна.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Үгүй.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой	Ийм зохицуулалт байхгүй.

зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж тус хуулийн төсөлд хариуцлагын талаар тодорхой тусгасан байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1 Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах

Монголбанк, Азийн хөгжлийн банк хамтран “Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зарчим, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох олон улсын шилдэг туршлага” болон “Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх” талаар судалгааг хийж судалгааны үр дүнд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан хуультай байхыг дэмжиж, Монголбанк санаачлан Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Тус хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төсөл батлагдсанаар бий болох эдийн засгийн үр дагавар, зардал тооцоо зэргийг судлахдаа холбогдох хэд хэдэн хуулиас гадна дараахь нэмэлт баримт бичиг, бусад материалыг ашигласан болно. Үүнд:

1. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулга, хуулийн төсөл,
2. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайлан,
3. Азийн хөгжлийн банкны ТА-9180 төслийн хүрээнд боловсруулсан Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зарчим, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох олон улсын шилдэг туршлага, 2017
4. Азийн хөгжлийн банкны ТА-9180 төслийн хүрээнд боловсруулсан “Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх судалгаа, 2017

5. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар,
6. Санхүүгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг Хамгаалах Шилдэг Туршлага, 2012
7. Дэлхийн Банк, Техникийн туслалцааны тайлан. “Монгол Улс: Санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих” (“ТА тайлан”).
8. Солонгос Улсын Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль.

5.2 Үнэлэлт дүгнэлт

Энэхүү үнэлгээний ажлын явцад албан бичгээр санал авах, олон улсын туршлага болон эрдэмтдийн хийсэн судалгаа, улс орнуудын сайн туршлага бүхий хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж болон олон улсын сайн туршлагатай харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэснээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийн зорилго нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэх эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн төслийн зохицуулалт хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд хуулийн төслийн зорилго үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

5.3.Зөвлөмж

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Харин үр нөлөөг тооцох ажиллагааны явцад хуулийн төслийн 12.1 дэх хэсэгт заасан³ санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хоорондын санхүүгийн үйлчилгээний талаарх маргааныг үнэ төлбөргүйгээр түргэн шуурхай, хараат бусаар шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүгийн омбудсмантай холбоотой хуулийн төслийг боловсруулж, батлуулах нь хуулийн төслийн хэрэгжилтэд эерэг үр нөлөөтэй гэж үзэж байна.

³ Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хоорондын санхүүгийн үйлчилгээний талаарх маргааныг үнэ төлбөргүйгээр түргэн шуурхай, хараат бусаар шийдвэрлэх чиг үүргийг бие даасан, мэргэшсэн санхүүгийн омбудсман хэрэгжүүлж болох бөгөөд түүний эрх зүйн байдал, үйл ажиллагаа, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.

___o0o___